



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/003/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Баянхонгор хот

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор:	Б.Мөнхбат
Утас: 99007576	Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a>
Аудитын менежер	М.Алтантуяа
Утас: 99061829	Цахим хаяг: <a href="mailto:altantuyam@audit.gov.mn">altantuyam@audit.gov.mn</a>
Аудитор	Д.Оюун-Эрдэнэ
Утас: 88916603	Цахим хаяг: <a href="mailto:oyun-erdenede@audit.gov.mn">oyun-erdenede@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	6
3. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ .....	10
4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	10
5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХАА	Хөдөө аж ахуй
ХААК	Хөдөө аж ахуйн кластер
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.03.16 № 2/149

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймгийн “Баян Өсөх Агро” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн үзүүлэлтүүд, зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас “Баян Өсөх Агро” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Сайнхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

### Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- 2025 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасан хугацаанд гаргаж ирүүлээгүй. Төрийн аудитын байгууллагаас тайлангаа ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн ч хуулийн хугацаанд ирүүлээгүй;

- Тайлант онд худалдан авсан 62,348.9 мянган төгрөгийн шатахуун, тос тосолгооны материал, өвс тэжээлийн нөөцийн 556,416.0 мянган төгрөгийн орлого, зарлага, нөөцийн барааны эхний үлдэгдэл 132,909.0 мянган төгрөгийн анхан шатны баримт байхгүй, хадаж бэлтгэсэн өвс, тариалж хураан авсан тэжээл, төмс, хүнсний ногооны өртгийг тооцож бүртгээгүй, ерөнхий журнал, ерөнхий дэвтэр хөтлөөгүй байна.

6426050424  
/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-  
албан тоот.docx

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”, 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.2-т “журналд бичих”, 14.3.3-т “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх” гэсэн заалтуудыг зөрчсөн мөн иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Дорнод аймгийн Халх гол сумын хадлангийн талбайгаас өвс бэлтгэж, Баянхонгор аймгийн Бууцагаан сумд ногоон тэжээл, Өлзийт сумын Бумбатын тариалангийн талбайд ногоон тэжээл, төмс, хүлэмжид хүнсний ногоо тариалж хураан авсан боловч үйлдвэрлэлийн бодит өртгийг тооцоолж бүртгээгүй байна.

Эрдэнэцогтын сумын Хөшөөтийн аманд ногоон тэжээл тариалсан боловч ургаагүй байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тайлант онд Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 9/61 дугаар тогтоолоор 194,124.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 13 нэр төрлийн үндсэн хөрөнгө, 246,182.0 мянган төгрөгийн 6 төрлийн эргэлтийн хөрөнгө, 7/40 дугаар тогтоолоор 6,000.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Toyota hiace автомашин, 10/79 дугаар тогтоолоор 0 төгрөгийн үлдэх өртөгтэй Lexus 470 автомашиныг балансаас баланс хооронд шилжүүлэн хүлээн авсан байна.

Мөн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын дагуу Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 99 дүгээр захирамжаар ХААК төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төслийн ХАА-н машин тоног төхөөрөмж болох 808,800.0 мянган төгрөгийн 5ш автомашиныг орлогод авч бүртгэж тайлагнасан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын 2025 онд 05 дугаар сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Тайлант онд аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх ажлын гэрээгээр аймгийн ОНХС-аас 100,000.0 мянган төгрөг, стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгүүлэхээр аймгийн ЗДТГ-аас жилийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 50,000.0 мянган төгрөгийг хүлээн авч орлогоор бүртгэсэн байна.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>187,455,453.33</b>	<b>683,115,976.45</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>14,273,405.45</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	<b>14,273,405.45</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	-	<b>14,273,405.45</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	-	14,273,405.45
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>14,767,333.33</b>	<b>17,399,423.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	863,013.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>14,767,333.33</b>	<b>16,536,410.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	14,767,333.33	15,648,133.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	888,277.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>39,779,120.00</b>	<b>39,779,120.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	39,779,120.00	39,779,120.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	-	<b>10,648,028.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	-	<b>10,648,028.00</b>
35420	Аж ахуйн материал	-	6,238,028.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	2,310,000.00
35460	Хүнсний материал	-	118,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	1,982,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	<b>601,016,000.00</b>
36200	Үрийн нөөц	132,909,000.00	601,016,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>132,909,000.00</b>	<b>589,633,000.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	-	<b>1,055,224,546.08</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	-	<b>1,055,224,546.08</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	107,495,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(25,215,309.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	1,043,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(151,283,333.31)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	133,949,890.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(53,516,801.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	495,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>187,455,453.33</u></b>	<b><u>1,738,340,522.53</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>40,000,000.00</u></b>	<b><u>252,345,251.47</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	40,000,000.00	252,345,251.47
<b>41300</b>	<b>Өглөг</b>	-	46,205,680.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	17,585,680.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	28,620,000.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>40,000,000.00</b>	<b>206,139,571.47</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	40,000,000.00	144,878,543.09
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	24,198,965.60
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	12,895,069.78

Баянхонгор аймгийн “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	-	24,166,993.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>147,455,453.33</u></b>	<b><u>1,485,995,271.06</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>147,455,453.33</b>	<b>1,485,995,271.06</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,000.00	10,000.00
51100	Өмч: - төрийн	10,000.00	10,000.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>147,445,453.33</b>	<b>1,485,985,271.06</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	147,449,933.33	147,445,453.33
51220	Тайлант үеийн үр дүн	(4,480.00)	1,338,539,817.73
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>187,455,453.33</u></b>	<b><u>1,738,340,522.53</u></b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	-	<b>1,684,942,093.28</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>1,534,942,093.28</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>1,534,942,093.28</b>
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	-	1,008,924,546.08
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	-	246,182,000.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	-	279,835,547.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	<b>150,000,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>150,000,000.00</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	150,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,480.00</b>	<b>346,402,275.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,480.00</b>	<b>265,402,275.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,480.00</b>	<b>265,402,275.55</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,480.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,480.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>265,402,275.55</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	230,702,275.55
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		34,700,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>81,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>81,000,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж		21,000,000.00
223001	Бусад хөрөнгө		60,000,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(4,480.00)</u></b>	<b><u>1,338,539,817.73</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(4,480.00)</u></b>	<b><u>1,338,539,817.73</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>_____ -</b>	<b><u>377,455,547.20</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>377,455,547.20</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>-</b>	<b>377,455,547.20</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>-</b>	<b>227,455,547.20</b>
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/		227,455,547.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>150,000,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>150,000,000.00</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		150,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>4,480.00</u></b>	<b><u>363,182,141.75</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,480.00</b>	<b>363,182,141.75</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,480.00</b>	<b>363,182,141.75</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>-</b>	<b>69,052,769.00</b>
210101	Үндсэн цалин		69,052,769.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>-</b>	<b>4,612,787.00</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		4,612,787.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>-</b>	<b>220,438,312.0</b>
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/		159,860,752
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		60,577,560
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,480.00</b>	<b>69,078,273.75</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,480.00	
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/		143,100.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/		68,935,173.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(4,480.00)</u></b>	<b><u>14,273,405.45</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(4,480.00)</b>	<b>14,273,405.45</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>4,480.00</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>14,273,405.45</b>

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	10,000.00	00.00	147,449,933.33	147,459,933.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00			00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,000.00	00.00	147,449,933.33	147,459,933.33
C07	Тайлант үеийн үр дүн	00.00		(4,480.00)	(4,480.00)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,000.00	00.00	147,445,453.33	147,455,453.33
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	10,000.00	00.00	147,445,453.33	147,455,453.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00		00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,000.00	00.00	147,445,453.33	147,455,453.33
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,338,539,817.73	1,338,539,817.73
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,000.00	00.00	1,485,985,271.06	1,485,995,271.06

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/Д	Зардал	2025 он		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Бизнес төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,213,280,000.00	377,455,547.20	835,824,452.80	31.1
2	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,213,280,000.00	377,455,547.20	835,824,452.80	31.1
3	Санхүүгийн дэмжлэгээр	300,000,000.00	150,000,000.00	150,000,000.00	50.0
4	Үндсэн үйл ажиллагааны орлого	913,280,000.00	227,455,547.20	685,824,452.80	24.9
6	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>887,775,120.00</b>	<b>623,341,478.12</b>	<b>264,433,641.88</b>	<b>70.2</b>
7	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>887,775,120.00</b>	<b>623,341,478.12</b>	<b>264,433,641.88</b>	<b>70.2</b>
8	Ажиллах хүчний зардал	594,564,400.00	117,366,359.80	477,198,040.20	19.7
9	Үр бордооны зардал	90,685,000.00	42,227,500.00	48,457,500.00	46.6
10	Тээвэр, шатахуун	94,180,000.00	147,017,028.34	(52,837,028.34)	156.1
11	<b>Бусад зардал</b>	<b>108,345,720.00</b>	<b>315,461,883.32</b>	<b>(207,116,163.32)</b>	<b>291.2</b>
12	Гэрэл, цахилгаан	51,183,720.00	3,694,062.09	47,489,657.91	7.2

**Баянхонгор аймгийн “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

13	Түлш, халаалт	14,700,000.00	1,427,625.00	13,272,375.00	9.7
14	Бичиг хэрэг	800,000.00	133,400.00	666,600.00	16.7
15	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	99,000.00	201,000.00	33.0
16	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,200,000.00		7,200,000.00	0.0
17	Тавилга эд хогшил	34,162,000.00		34,162,000.00	0.0
18	Тоног төхөөрөмж		21,000,000.00		
19	Тээврийн хэрэгсэл		60,000,000.00		
20	Сэлбэг хэрэгсэл		22,955,024.00	(22,955,024.00)	
21	Аж ахуйн материал худалдан авах		10,776,678.00	(10,776,678.00)	
22	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		91,179,154.51	(91,179,154.51)	
23	Даатгалын үйлчилгээ		143,100.00	(143,100.00)	
24	Тээврийн хэрэгслийн татвар		551,475.00	(551,475.00)	
25	Тээврийн хэрэгслийн оношлогоо		616,000.00	(616,000.00)	
26	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		91,200.00	(91,200.00)	
27	Бараа үйлчилгээний бусад зардал	-	93,203,092.00		
28	Газрын төлбөр		1,062,306.00	(1,062,306.00)	
29	Бусад зардал		9,798,473.38	(9,798,473.38)	
30	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>325,504,880.00</b>	<b>(245,885,930.92)</b>		

### 3. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэх талаар тусгах шаардлагатай байна.

### 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 187,966.9 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрсэнийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант онд үнэ төлбөргүй шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэхдээ 132,287.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг, тээврийн хэрэгсэлээр, 2,157.0 мянган төгрөгийн компьютер, принтер, бусад үндсэн хөрөнгийг машин, тоног төхөөрмжөөр, нийт 134,444.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг буруу ангилан бүртгэж тайлагнасан байна.

2. Хуримтлагдсан элэгдэлтэй шилжиж ирсэн үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 1,342.0 мянган төгрөгийн зөрүүтэй, тайлант оны элэгдлийн зардлыг 200.0 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэж тайлагнасанаас хуримтлагдсан элэгдэл дансны эцсийн үлдэгдэл 1,142.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.

3. Бартераар буюу 52,380.0 мянган төгрөгийн өвс нийлүүлэн үндсэн хөрөнгө

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

худалдан авсан бөгөөд орлогоор тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”, 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.5-т “бүх орлого”, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 784,953.2 мянган төгрөгийн зөрчил илэрч 33,279.3 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, 751,673.9 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

#### **4.1 Зөвлөмж**

1. Нэг ажилтны 7-10 дугаар сарын 4,599.7 мянган төгрөгийн цалин хөлс, түүнээс суутган тооцсон НДШ, ажил олгогчийн НДШ-ийг мэдээлээгүй, Ажилчдын цалин хөлснөөс суутгасан НДШ, ажил олгогчийн төлөх НДШ нийт 24,167.0 мянган төгрөг, ажилтны төлөх ХХОАТ 8,008.4 мянган төгрөгийг төлөөгүй, өр төлбөрөөр тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6-т "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэг ажилтны НДШ-ийг нөхөн мэдээлэх, НДШ болон ХХОАТ-ын өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлэв.

#### **4.2 Албан шаардлага**

1. Тайлант онд худалдан авсан 62,348.9 мянган төгрөгийн шатахуун, тос тосолгооны материал, өвс тэжээлийн нөөцийн 556,416.0 мянган төгрөгийн орлого, зарлага, нөөцийн барааны эхний үлдэгдэл 132,909.0 мянган төгрөгийн анхан шатны баримт байхгүй, хадаж бэлтгэсэн өвс, тариалж хураан авсан тэжээл, төмс, хүнсний ногооны өртгийг тооцож бүртгээгүй, ерөнхий журнал, ерөнхий дэвтэр хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.2-т “журналд бичих”, 14.3.3-т

“дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Салбарын онцлогийн дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, НББ-ийн тухай хууль, СТОУС-ыг мөрдөж ажиллах, хадаж бэлтгэсэн өвс, тариалсан тэжээл, төмс, хүнсний ногооны өөрийн өртгийг үнэн зөв тооцож бүртгэн, орлого зардлаа зөв ангилан бүртгэж тайлагнах, холбогдох анхан шатны баримтыг иж бүрэн бүрдүүлж ажиллах.

2. 2022 онд ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор зориулалтаар 80,904 мкв талбай бүхий 15 жилийн хугацаатайгаар олгосон газрыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрыг НББОУС-38 Биет бус хөрөнгө стандартын дагуу нягтлан бодох бүртгэлд бүртгэж зөрчлийг арилгах.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2027 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

#### 4.3 Аудитаар илэрсэн бусад асуудал

Санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасан хугацаанд гаргаж ирүүлээгүй, Төрийн аудитын байгууллагаас тайлангаа ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн ч заасан хугацаанд ирүүлээгүй асуудалд аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн НББ-ийн улсын байцаагчийг арга хэмжээ авч ажиллах талаар албан бичиг хүргүүлж шийдвэрлэсэн болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийт 134,444.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг буруу ангилан бүртгэж тайлагнасан байна.	1	134,444.9			1	134,444.9	1	134,444.9		
Хуримтлагдсан элэгдэлтэй шилжиж ирсэн үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 1,342.0 мянган төгрөгийн зөрүүтэй, тайлант	1	1,142.0			1	1,142.0	1	1,142.0		

**Баянхонгор аймгийн “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

оны элэгдлийн зардлыг 200.0 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэж тайлагнаснаас хуримтлагдсан элэгдэл дансны эцсийн үлдэгдэл 1,142.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.									
Бартераар буюу 52,380.0 мянган төгрөгийн өвс нийлүүлэн үндсэн хөрөнгө худалдан авсан бөгөөд орлогоор тайлагнаагүй байна.	1	52,380.0	1	52,380.0			1	52,380.0	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>187,966.9</b>	<b>1</b>	<b>52,380.0</b>	<b>1</b>	<b>135,586.9</b>	<b>1</b>	<b>187,966.9</b>	

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд худалдан авсан 62,348.9 мянган төгрөгийн шатахуун, тос тосолгооны материал, өвс тэжээлийн нөөцийн 556,416.0 мянган төгрөгийн орлого, зарлага, нөөцийн барааны эхний үлдэгдэл 132,909.0 мянган төгрөгийн анхан шатны баримт байхгүй, хадаж бэлтгэсэн өвс, тариалж хураан авсан тэжээл, төмс, хүнсний ногооны өртгийг тооцож бүртгээгүй, ерөнхий журнал, ерөнхий дэвтэр хөтлөөгүй байна.	1	751,673.9			1	751,673.9		
2	2022 онд ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор зориулалтаар 80,904 кв талбай бүхий газрыг 15 жилийн хугацаатайгаар олгосон ба санхүүгийн тайланд бүртгэлгүй байна.	1	-			1	-		
3	Нэг ажилтны 7-10 дугаар сарын 4,599.7 мянган төгрөгийн цалин хөлс, түүнээс суутган тооцсон НДШ, ажил олгогчийн НДШ-ийг мэдээлээгүй, Ажилчдын цалин хөлснөөс суутгасан НДШ, ажил олгогчийн төлөх НДШ нийт 24,167.0 мянган төгрөг, ажилтны төлөх ХХОАТ 8,008.4 мянган төгрөгийг төлөөгүй, өр төлбөрөөр тайлагнасан байна.	1	33,279.3					1	33,279.3
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>784,953.2</b>			<b>2</b>	<b>751,673.9</b>	<b>1</b>	<b>33,279.3</b>

-----oOo-----